



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 0/45

Номгон

Иргэн Г.Цагаанчулуун, О.Бямбажаргал
нарын захирамжаар өмчлүүлсэн газрын
талбайн хэмжээ залруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн, 60.1.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өөрийн эзэмшил газраа өмчлөх явцад хэмжилтийн алдаанаас шалтгаалж талбайн хэмжээ зөрүүтэй болсон иргэн Г.Цагаанчулуун, О.Бямбажаргал нарын өмчлөлийн газрын талбайн хэмжээг залруулсугай.

2.Газар өмчлөгчдийн үндсэн мэдээллийг хавсралтаар баталсугай.

3.Холбогдох хууль тогтоомжид заасан хүрээнд өмчлөх эрхээ хэрэгжүүлж, цаашид өөрийн өмчлөлийн газрын талбайн хэмжээг өөрчилсөн зөрчил гаргахгүй байхыг газар өмчлөгчдөд, газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Баянхонгор сумын Засаг дарга (М.Насанбат), газрыг улсын бүртгэлд бүртгэж ажиллахыг Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Энхбаяр), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл) нарт тус тус даалгасугай.

5.Энэ захирамж гарсантай холбогдуулан иргэдийн анхны өмчлөлийн 2008 оны 78 дугаар захирамжийн 22 дугаар хэсгийн иргэнтэй холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.

ДАРГА

Э.ЭНХБАТ

D:\2026\1.Zakhiramj\Захирамж 01-01-01-.docx

626610105

Аймгийн Засаг дарга 2006 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 1/45 дугаар захирамжийн хавсралт



ГАЗАР ӨМЧЛӨХ ЗАХИРАМЖИЙН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРЖ БАЙГАА ИРГЭДИЙН НЭРС

д/д	Газар өмчлөгчийн				Гэр бүлийн хэрэгцээнд өмчилж авсан болон залруулгын захирамж					Залруулагдах газрын		
	Овог	Эцэг/эх-ийн нэр	Нэр	Регистрийн дугаар	Он.сар.өдөр	Дугаар	Хавсралтад орсон дугаар	Газрын хаяг	Өмнө нь гарсан талбайн хэмжээ /м2/	Газрын хаяг	Талбайн хэмжээ /м2/	Нэгж талбарын дугаар
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	Хөхнуур	Очир	Бямбажаргал	BM92042503	2008.03.07	78	22	3--6--6а	583	Дуурсах 3 дугаар баг Нөмөр 9 дүгээр гудамж 917 тоот	557	6409002377
2	Баянцагаан	Гэлэгмаа	Цагаанчулуун	BT86112211	2008.03.08	78	22	3--6--6б	500	Дуурсах 3 дугаар баг Нөмөр 9 дүгээр гудамж 919 тоот	498	6409002378

-----oOo-----